ТӨВ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2025/25/-НА-СТА-ТТЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2025 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582  Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463  Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287  Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

**АГУУЛГА**

1.ХАРААТ УС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** 5
**3.4.1 Мөнгөн хөрөнгө ....... Error! Bookmark not defined.**
**3.5.2 Авлага ....... Error! Bookmark not defined.**
**3.5.6 Үндсэн хөрөнгө ....... Error! Bookmark not defined.**
**3.5.7 Өр төлбөр ....... Error! Bookmark not defined.**
**3.5.10 Засгийн газрын хувь оролцоо ....... Error! Bookmark not defined.**
**3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ....... Error! Bookmark not defined.**
**4. АУДИТЫН ТАЙЛАН ....... Error! Bookmark not defined.**
**4.1 Ерөнхий зүйл ....... Error! Bookmark not defined.**
**4.2 Материаллаг байдал ....... Error! Bookmark not defined.**
**4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....... Error! Bookmark not defined.**
**4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....... Error! Bookmark not defined.**
**4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт Error! Bookmark not defined.**
**4.7.1 Завсрын аудитын талаар ....... Error! Bookmark not defined.**
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....... 9**
**5.2 Албан шаардлага ....... 9**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЗГУМС | Засгийн газрын удирдлага мэдээллийн систем |

## 1.ХАРААТ УС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tov@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.21 № 01/237

танай ____________ -ны № ____________ -т

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА С. ЦАГААНБААТАР
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дээд шатны төсөвт тодотгол хийснээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 106,454.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 524,980.5 мянган төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 649,870.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 7,971,000.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг Засаг даргын Тамгын газрын биет бус хөрөнгийн дансанд бүртгэж тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Цээл сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ нь 8 зорилт, 31 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батламжлагдсанаас гүйцэтгэлээр 26 арга хэмжээг 100 хувь, 5 арга хэмжээг 70-88 хувьтай хэрэгжүүлсэн байна. Нийт үнэлгээгээр 90,0 хувьтай буюу "Үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

412506428

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болovч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | 898,052.4 | 898,052.4 |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | 484,889.7 | 683,115.8 |
| 33 | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | 234,647.7 | 246,530.1 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | 178,515.0 | 178,515.0 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | 2,311,243.7 | 10,482,212.5 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | 2,311,243.7 | 10,482,212.5 |
| 39200 | **Биет хөрөнгө** | | 1,884,857.7 | 2,082,720.5 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 13 | 426,386.0 | 8,399,492.0 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | 3,209,296.2 | 11,581,813.1 |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 852.9 | 4,957.1 |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15а, 15б | 852.9 | 4,957.1 |
| 41300 | **Өглөг** | 17а, 17б | 852.9 | 4,957.1 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | 3,208,443.3 | 11,576,856.0 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | | 3,208,443.3 | 11,576,856.0 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 716,990.2 | 716,990.2 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | | 2,176,382.5 | 10,544,795.2 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 315,070.6 | 315,070.6 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | 3,209,296.2 | 11,581,813.1 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | 3,352,996.4 | 10,670,186.8 |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | 392,692.8 | 592,708.1 |
| 110 | **Орлогын албан татвар** | | 231,152.1 | 468,991.0 |
| 1100 | **Хувь хүний орлогын албан татвар** | | 242,152.1 | 468,991.0 |
| 113 | **Хөрөнгийн албан татвар** | | 57,228.0 | 48,276.8 |
| 118 | **Бусад татвар, төлбөр, хураамж** | | 104,312.7 | 75,440.4 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 1а, 1б | 485,891.7 | 8,403,875.8 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | | 485,891.7 | 8,403,875.8 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | 2,474,411.9 | 1,673,602.8 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2а, 2б | 2,941,291.3 | 2,125,715.5 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 2,607,995.3 | 1,928,320.1 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 1,372,642.7 | 1,899,069.2 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 482,758.7 | 737,044.5 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 59,324.6 | 96,566.4 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 73,087.8 | 569,759.7 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | | 52,240.0 | 53,838.5 |
| 2105 | **Норматив зардал** | | 92,220.0 | 129,054.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 1,621.0 | 56,698.4 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 7,168.2 | 11,476.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 50,554.1 | 17,816.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 553,668.4 | 226,815.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 1,235,352.6 | 29,250.9 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | 333,296.0 | 197,395.3 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | 411,705.1 | 8,544,471.3 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 42,860.0 | 176,058.6 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | 368,845.1 | 8,368,412.7 |

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,840,138.4 | 0 | 2,840,138.4 |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | -450.8 | 0 | -450.8 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 2,839,687.7 | 0 | 2,839,687.70 |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | -89.5 | 0 | -89.5 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 368,845.1 | 0 | 368,845.1 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,208,443.3 | 0 | 3,208,443.3 |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 3,208,443.3 | 0 | 3,208,443.3 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 3,208,443.3 | 0 | 3,208,443.3 |
| **19** | Тайлант үеийн үр дүн | 8,368,412.7 | 0 | 8,368,412.7 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 11,576,856.0 | 0 | 11,576,856.0 |

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023.12.31 | 2024.12.31 |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | | 392,692.8 | 592,708.1 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | 231,152.1 | 468,991.0 |
| **110** | **Орлогын албан татвар** | | 242,152.1 | 468,991.0 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | | 57,228.0 | 48,276.8 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | | 104,312.7 | 75,440.4 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | | 33,948.2 | 15,129.2 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | | 68,277.7 | 58,462.1 |
| **1181** | **Газрын төлбөр** | | 2,086.8 | 1,849.0 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | | 221,917.6 | 290,886.6 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | 221,917.6 | 290,886.6 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 2,474,411.9 | 1,671,802.2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | 2,486,411.2 | 1,764,385.5 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 2,486,411.2 | 1,764,385.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 1,248,048.2 | 1,733,850.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 481,706.6 | 742,618.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 58,997.6 | 89,233.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 73,223.8 | 569,760.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 25,648.3 | 41,299.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 102,242.5 | 108,344.6 |
| **2105** | **Норматив зардал** | | 4,800.0 | 57,990.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 7,168.2 | 11,476.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 59,065.0 | 20,876.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 435,196.3 | 92,251.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 1,238,362.9 | 30,535.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 602,611.2 | 791,011.5 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | | 405,968.4 | 491,348.7 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | | 405,968.4 | 491,348.7 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | 405,968.4 | 491,348.7 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | -405,968.4 | -491,348.7 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | -40,460.0 | -101,436.7 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | | 40,460.0 | 101,436.7 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | | 156,182.7 | 198,226.1 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | | 328,707.0 | 484,889.7 |
| **101** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 484,889.7 | 683,115.8 |
| **20** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 392,692.8 | 592,708.1 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,353,664.1** | **1,934,723.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,628,459.0** | **1,568,477.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,615,863.5** | **1,555,882.3** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **692,875.8** | **660,545.8** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **86,611.8** | **79,602.0** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **582,659.9** | **569,760.1** |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **31,084.5** | **31,082.5** |
| **2105** | **Норматив зардал** | **1,177.7** | **1,177.7** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **72,250.0** | **72,250.0** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **10,902.0** | **7,748.0** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **30,890.8** | **26,305.0** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **107,411.0** | **107,410.9** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,595.5** | **12,595.5** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,595.5** | **12,595.5** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **623,705.1** | **264,808.7** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **101,500.0** | **101,436.7** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,353,664.1** | **2,078,600.3** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,574,248.0** | **1,982,204.9** |
| **320001** | Орон нутгийн төсвөөс | 1,574,248.0 | 1,669,156.1 |
| **320002** | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.0 | 313,048.8 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **458,062,700.0** | **96,395,437.3** |
| **350001** | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 101,500,000.0 | 96,395,437.3 |
| **4** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 321,066,322.9 |
| **5** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 404,962,082.2 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **54** | **54** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2** | **2** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **26** | **26** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26** | **26** |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 134,774.5 | 309,485.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 74,946.4 | 147,434.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 66,844.0 | 129,799.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 34,257.0 | 82,073.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,264.6 | 9,631.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 0.0 | 0.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,236.30 | 9,123.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0.0 | 3,492.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,800.0 | 1,433.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,700.1 | 24,047.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.0 | 17,635.1 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.0 | 125.1 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 162,050.8 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.0 | 162,050.8 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 42,806.8 | 309,485.7 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 42,806.8 | 309,485.7 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | 0.0 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.0 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.0 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн алдаа байхгүй.

**Залруулаагүй алдаа**

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 34,011.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16,283.4 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

**1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

***Илрүүлэлт:***

1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 524,980.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 649,870.1 мянган төгрөг төвлөрсөн ба 16 нэр төрлийн орлогоос 5 нэр төрлийн орлого 26,626.4 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

### 5.3 Зөвлөмж

***Илрүүлэлт:***

1. Санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл татварын албанаас ирүүлсэн гүйцэтгэлийн мэдээтэй 7,385.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил бүтэн жилээр бэлтгэ тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж:***

Татварын орлогын биелэлтэд хяналт тавьж, татварын улсын байцаагчтай сар бүр тооцоо нийлж баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад

ирүүлнэ" заалтын дагуу ирүүлж, зөвлөмж болон албан шаардлагын биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **А** | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| **1** | Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| **2** | Засаг даргын тамгын газар | 1 | 1 | | | | 1 | | |
| **3** | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| **4** | Эмийн эргэлтийн сан | 1 | | 1 | | | | | |
| **5** | Орон нутгийн хөгжлийн сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | **6** | **1** | **4** | | | **1** | | |

**7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

**/мянган төгрөгөөр/**

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Засаг даргын Тамгын газар** | 3 | 8,066,300.0 | 2 | 7,978,100.0 | 1 | 88,200.0 | 3 | 8,066,300.0 | | |
| **Иргэдийн Төлөөлөгчдийн хурал** | 1 | 7,190.0 | | | 1 | 7,190.0 | 1 | 7,190.0 | | |
| **Эмийн эргэлтийн сан** | 1 | 5,478.5 | 1 | 5,478.5 | | | 1 | 5,478.5 | | |
| **Дүн** | **5** | **8,078,968.5** | **3** | **7,983,578.5** | **2** | **95,390.0** | **5** | **8,078,968.5** | **0** | **0** |

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | **/мянган төгрөгөөр/** |
| **Байгууллагын нэр** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Засаг дарга** | 2 | 34,011.5 | | | 1 | 26,626.5 | 1 | 7,385.00 |
| **Засаг даргын Тамгын газар** | 5 | 75,630.4 | 1 | 875.5 | 3 | 36,754.9 | 1 | 38,000.0 |